

Эрдмийн Зөвлөлийн 2011 оны 04 дүгээр сарын 04-ний

өдрийн хурлаар хэлэлцэн батлав.

ХИС-ийн ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ХИС-ийн Эрдмийн зөвлөл нь тус сургуулийн сургалт-эрдэм шинжилгээний үндсэн үйл ажиллагааны бодлого, чиглэлийг тодорхойлж, түүний онол арга зүйн түвшин, үр дүнг хэлэлцэж дүгнэлт гаргах, сургалт-арга зүй, эрдэм судлалын ажлыг мэргэжлийн ерөнхий удирдлагаар хангах зорилго бүхий хамтын удирдлагын эрдмийн байгууллага мөн.

Хоёр. ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

- 2.1. Эрдмийн зөвлөл дараах үндсэн чиг үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:
 - 2.1.1. Сургуулийн хөгжлийн стратеги болон мастер төлөвлөгөө, түүний хэрэгжилт үр дүнг хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт өгөх; Сургуулийн үндсэн үйл ажиллагааг зохицуулах нийтлэг дүрэм, журмыг хэлэлцэн батлах;
 - 2.1.2. Эрдэм шинжилгээ, сургалт үйлдвэрлэл, эдийн засгийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн дүгнэлт өгч, цаашдын зорилго, бодлого чиглэлийг тогтоох;
 - 2.1.3. Гадаад болон дотоодын эрдэм шинжилгээ, боловсролын байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулах, олон улсын нэр хүнд бүхий нийгэмлэгт гишүүнээр элсэх, хамтран ажиллах асуудлаар шийдвэр гаргах;
 - 2.1.4. Эрдэм шинжилгээний төв, лаборатор, хүрээлэнгийн үйл ажиллагаа, эрдэмшинжилгээний хурал семинар зохион байгуулах болон эрдэм шинжилгээ - судалгааны төслийн явц, үр дүнг хэлэлцэх;
 - 2.1.6. ХИС-ийн хүндэт профессор, хүндэт доктор, профессор, дэд профессор цол олгох, тус сургуулийн хүндэт цол, шагнал олгох;
 - 2.1.7. Эрдэм шинжилгээний ажлын санхүүжилтийн эх үүсвэр олох, судлаач багш, эрдэм шинжилгээний баг, хамтлаг, төвүүдийн ажлыг дэмжих шийдвэр гаргах;
 - 2.1.8. Улс орны нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан технологи, инновацийн бодлого, судалгааны чиглэл зэрэг төр засгийн дээд байгууллагад өргөн барих олон талт асуудлын талаар боловсруулсан хөтөлбөр, санал дүгнэлт, зөвлөмж, судалгааны төсөл, хуулийн төслийг хэлэлцэж санал дүгнэлт гаргах;
 - 2.1.9. Эрдмийн зөвлөлийн гишүүний боловсруулж дэвшүүлсэн асуудлыг нийт гишүүний гуравны нэгээс доошгүй хувь нь дэмжсэн тохиолдолд хэлэлцэж шийдвэрлэнэ.

Гурав. ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН УДИРДЛАГА, БҮРЭЛДЭХҮҮН

- 3.1. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Эрдмийн зөвлөлийн хурал байна.

3.2. Эрдмийн зөвлөл нь дарга, нарийн бичгийн даргатай байх бөгөөд нарийн бичгийн дарга нь хуралд бэлтгэх, Эрдмийн зөвлөлийн тогтоол шийдвэрийн биелэлтийн үр дүнг гаргаж мэдээлэх болон бичиг хэргийг хариуцна.

3.3. Эрдмийн зөвлөлийн гишүүн нь сургалт эрдэм шинжилгээний ажлын туршлагатай, эрдмийн зэрэг, цолтой, боловсрол шинжлэх ухааны салбарт ажиллаж байгаа тэргүүлэх эрдэмтэд байх ба Эрдмийн зөвлөлийн гишүүдийн 60-аас доошгүй хувь нь тус сургуулийн, үлдсэн хувь нь аж ахуйн нэгж болон төрийн бус байгууллага, салбарын эрдэмтэн судлаачдын төлөөлөл байна. Эрдмийн зөвлөлийн гишүүн ёслолын өмсгөлтэй байна.

3.4. Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнд нэгжээс нэр дэвшсэн эрдэмтэн профессорууд, бусад байгууллагын төлөөллийг захирлын саналаар оруулж батална.

3.5. Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёр жил тутам сэлгэн шинэчилж болох ба орсон гарсан тухай бүр нөхөн сонгож байна.

3.6. Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг боловсруулах, дүгнэлт гаргах, Эрдмийн зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор эрдэм шинжилгээ, сургалт, санхүү эдийн засгийн дэд зөвлөл, шинжлэх ухаан технологи инновацийн төв ажиллуулж болно.

Дөрөв. ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Эрдмийн зөвлөлийн гишүүний эрх:

4.1.1. Эрдмийн зөвлөлд хэлэлцэж байгаа асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх;

4.1.2. Эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж буй асуудлыг шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох;

4.1.3. Сургуулийн үйл ажиллагаанд шууд холбоотой асуудлыг Эрдмийн зөвлөлд оролцуулахаар санал оруулах;

4.1.4. Эрдмийн зөвлөлийн тогтоол, шийдвэрийн биелэлттэй танилцах, шалгах;

4.1.5. Сургуулийн хэмжээний зөрчил дутагдалтай аливаа асуудлын талаар Эрдмийн зөвлөлийн дарга болон холбогдох салбар сургуулийн захирал, бүрэлдэхүүн нэгжийн удирдлагад санал, дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх;

4.1.6. Эрдмийн зөвлөлийн гишүүн байхаас өөрийн хүсэлтээр татгалзах эрхтэй.

4.2. Эрдмийн зөвлөлийн гишүүний үүрэг:

4.2.1. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаанд идэвхи санаачлагатай оролцох

4.2.2. Эрдмийн зөвлөлийн шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах талаар санаачлага гаргах, биечлэн үлгэрлэн оролцоно.

Тав. ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН, ХУРАЛДААНЫ ДЭГ, ШИЙДВЭР ГАРГАХ

5.1. Эрдмийн зөвлөлийн бүх гишүүдийн ээлжит хуралдааныг хичээлийн жилд 4-өөс доошгүй хийнэ. Шаардлагатай үед ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна.

5.2. Эрдмийн зөвлөл хуралдаанаа бүх гишүүдийн 2/3-оос доошгүй ирцтэй хийнэ. Хуралдааны хэлэлцэх асуудал, холбогдох баримт бичгийг хурал эхлэхээс хоёр хоногийн өмнө тараана.

5.3. Эрдмийн зөвлөл хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргаж, тэмдэглэл хөтлөх ба эрдмийн цол олгохоос бусад асуудлыг илээр санал хурааж шийдвэрлэнэ. Гадаадын иргэнд хүндэт цол олгох асуудлыг илээр санал хурааж шийдвэрлэнэ.

5.4. Эрдмийн зөвлөлийн хуралдааны шийдвэрийг санал хураалтанд оролцсон гишүүдын 3/4 хувийн эерэг саналаар хүчинтэйд тооцно. Эрдмийн зөвлөлийн хурлын тогтоолд хуралдааны дарга гарын үсэг зурна.